

СУДАЛГАА

№6 ХООЛ БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦООНЫ ЗАРИМ ЭМГЭГ ӨӨРЧЛӨЛТ ТҮҮНД
НӨЛӨӨЛӨХ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ СУДЛАХ НЬ

Г.Чанцалдулам¹, Ю.Баасандорж¹, Н.Баасанжаргал¹, Х.Зандармаа¹, Д.Оюунцэцэг²
АШУУИС Говь-Алтай Анагаах Ухааны Сургууль
Эмзүй Био-Анагаахын тэнхим
Цахим шуудан: Chantsaldulam.g@mnums.edu.mn
Умач: 86200095


Үндэслэл: Цөс ба нойр булчирхайн эмгэг өөрчлөлт нь дэлхийн нийт хүн амын 6%-д илэрч байна. Монгол орны өвчлөлийн хөдлөл зүйн байдалд хийсэн судалгаагаар хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл сүүлийн 10 жилд тогтмол II-т, нас баралт түвшингээр IV-т эрэмблэгдэж байгаагаас дээрх өвчлөлтэй холбоотой мэс заслын хувь (14.2%) өндөр гарчээ¹. Баруун бүсийн аймгуудад 2022 оны байдлаар 10000 хүн амд ноогдох хоол боловсруулах тогтолцооны өвчлөл хамгийн өндөр буюу 23,5% байсан бөгөөд зүүн бүсийн аймгуудын өвчлөлтэй харьцуулахад 8.6% дахин өсөлттэй байна. Уг бүс нутгаас Говь-Алтай аймаг нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөлөөр тэргүүлж байна гэсэн эрүүл мэндийн үзүүлэлт гаржээ. Техник технологи давшингуй хөгжиж буй энэ үед хүн амын дундах хөдөлгөөний хомсдол, амьдралын буруу хэв маягтай холбоотойгоор хоол боловсруулах замын өвчлөл залуужих хандлагатай байна². АНУ хийгдсэн судалгаагаар 20-40 насны залуучуудад цөсний хүүдийн үрэвсэл түгээмэл тохиолддог ч эмнэлзүйн шинж тэмдэг хожуу үед илэрч мөн цөсний хагалгаа хийлгэж буй тохиолдлын 4-20% нь 30-с доош насны залуучууд байсан бөгөөд энэ нь "Z" үеийнхний дунд цөсний хүүдийн өөрчлөлт байгааг харуулж байна³. Иймээс оюутан залуусын

дундах цөс болон нойр булчирхайн эмгэг өөрчлөлт, тархалт, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг судлах нь бидний судалгааны үндэслэл болж байна.


Зорилго: Цөс болон нойр булчирхайн эмгэг өөрчлөлтийн тархалт болон түүнд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлийг судлах

Материал, арга зүй: АШУУИС-ийн ГАА дахь салбар Анагаах Ухааны сургуулийг түшиглэн 2025 оны 01 сараас 2025 оны 04 сарын хооронд нэг агшийнгийн судалгааны загвар, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар, ДЭМБ насны ангиллын дагуу I-VI дамжааны 200 оюутанг сонгон авч судалгаанд хамруулсан. Судалгаанд оролцогчдоос таниулсан зөвшөөрөл авсан болно. Судалгааг дескриптив буюу нэг агшингийн загвараар, цөсний хүүдийн цочмог үрэвслийн оношлогоо эмчилгээний эмнэлзүйн зааврын дагуу асуумж /амьдралын хэв маяг, хорт зуршил, зовиур бий эсэх, тархвар судлал/ авч, Ultrasound SUN-800D хэт авиан аппаратаар үзүүлэлтүүдийг тодорхойлов. Статистикийн боловсруулалтын математик үйлдлүүдийг SPSS-25.0 for Windows* программыг ашиглан хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын үр дүн: Судалгаанд нийт 200 оюутан хамрагдсанаас 120 (60%) эмэгтэй, 80 (40%) эрэгтэй оюутнуудыг хамруулсан.



Зураг 1. Өглөөний цайгаа тогтмол уудаг эсэх




Зураг 2. Өдөрт уух шингэний хэмжээ

Нийт 200 оюутныг асуумж хуудас бөглүүлэхэд 128 (64%) нь өглөөний цайгаа уудаггүй (зураг 1), байсан бол өдөрт уух шингэний хэмжээгээ бүрэн авч чаддаг эсэхийг тодруулахад 147 буюу (73,5%) нь өдөрт уух шингэнээ хангалттай авч чаддаггүй байна. (Зураг 2)



Зураг 5. Цөсний хүүдийн их бие хэсгийн нугаларалт



(I)

(II)


(III)

Зураг 3. Цөс болон нойр булчирхайн эмгэг өөрчлөлтийн тархалтын түвшин




Зураг 4. Цөс болон нойр булчирхайн эмгэг өөрчлөлт хүйсийн харьцаагаар I-Цөс өтгөрөл, II-Цөс нугаларсан эсэх, III-Нойр булчирхайн ЭХО ойлт/

Харин Хэт авиан шинжилгээгээр цөс болон нойр булчирхайн эмгэг өөрчлөлт 104 (52%-д нь илэрсэн (Зураг 3) бол хүйсийн харьцаагаар авч үзвэл эмэгтэй хүйсэд эмгэг өөрчлөлтүүд давамгайлалтай илэрч (I-цөсний өтгөрөл 67%, II-цөсний нугаларал 62.5%, III-нойр булчихайн эхо ойлт 67.1%) байлаа. (Зураг 4)




Зураг 6. Цөсний хүүдийн хүзүү хэсгийн нугаларалт

Хэт авиан шинжилгээгээнд 64 буюу (32%)-д цөсний хүүдийн хүзүү болон их бие хэсгийн нугаларалтай байна. (Зураг 5,6)



Зураг 7. Цөс чулуу



Зураг 8. Цөс өтгөрөлтэй, цөсний хүүдий сунасан

Харин нийт оролцогчдын 1 буюу (0.5%) нь цөсний хүүдийд чулуутай (Зураг 7) тодорхойлогдож 47% нь цөсний өтгөрөлтэй байлаа. (Зураг 8)



Зураг 9. Нойр булчирхайн эхо ойлт



Зураг 10. Цөс хүүдийн ургацаг

Мөн нийт оролцогчдын 48.5% -д нь нойр булчирхайн эхо ойлт ихэссэн байна. (Зураг 9)

Шинээр 5 буюу (2.5%)-д цөсний хүүдийн ургацаг нь хэт авиан шинжилгээгээр батлагдлаа. (Зураг 10)

Хэлцэмж: Судлаач Б.Нандинцэцэг, К.Ерболат¹ нарын судалгаанд нийт 100 оюутанг хамруулан ЭМШУИС-ийн оюутнуудын дундах цөсний хүүдий ба бөөрний эмгэг болон түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг судлахад оюутнуудын дунд цөсний өтгөрөл илэрч байгаа нь өглөө унд уухгүй хоосон явж улмаар цөс нугаларах шинж илрэх

үндсэн нөхцлийг бүрдүүлж байна гэж үзсэн байна.

Судлаач Farah Naaz Kazi², Shaurav Ghosh², JV Pranav Sharma³, Shwetha Saravanan³, Sanjana Patil³ нарын 2022 онд АНУ-д хийгдсэн "судалгаанд 20-40 насны залуучуудыг хамруулсан бөгөөд уг насны бүлэгт цөсний хүүдийн эмгэг өөрчлөлт үрэвсэл түгээмэл тохиолддог ч эмнэлзүйн шинж тэмдэг хожуу үед илэрч мөн цөсний хагалгаа хийлгэж буй нийт тохиолдлын 4-20% нь 30-с доош

насны залуучууд байсан бөгөөд энэ нь "Z" үеийнхний дунд цөсний хүүдийн өөрчлөлт байгааг харуулж байна.

Судлаач Hyung Sun Kim¹, Seong Kyung Cho³, Chang Soo Kim³, Joon Seong Park³ нарын судалгаанд хэвлийн хөндийн хэт авиан шинжилгээгээр хэвийн бус цөсний эмгэг өөрчлөлтийг судалж үзэхэд БЖИ, таргалалт, хэвлийн өөх, бодисын солилцооны синдром, чихрийн шижин зэрэг нь залуу үеийнхний дундах цөсний эмгэг өөрчлөлтийг үүсгэх эрсдэлт хүчин зүйл хэмээн тодорхойлсон байна.

Дүгнэлт: Цөс болон нойр булчирхайн эмгэг өөрчлөлтийн тархалтын түвшинг тогтооход 52%-д нь эмгэг өөрчлөлт илэрч байна. Цөс болон нойр булчирхайн эмгэг өөрчлөлтөнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлээс 64% нь өглөөний цайгаа уудаггүй, 73.5% нь өдөрт уух шингэнээ хангалтай авч чаддаггүй байна. Хэт авиан шинжилгээгээр цөс болон нойр булчирхайн эмгэг өөрчлөлтийн үзүүлэлтэнд цөсний өтгөрөлт 47%, нугаралт 32%, нойр булчирхайн эхо ойлт 48.5% ихэссэн байлаа.

Ёс зүйн зөвшөөрөл: АШУҮИС-ийн Говь-Атай Анагаах Ухааны Сургуулийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын хорооны 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн №2025/3-17 тоот хурлаар хэлэлцүүлэн ёс зүйн зөвшөөрөл авсан.

Талархал: Энэхүү судалгааны ажлыг хийхэд мэргэжлийн үнэтэй заавар зөвлөгөө өгч, тусалж дэмжсэн АШУҮИС-ийн Говь-Алтай АУС-ийн сургуулийн эрдэмтэн багш нар, нийт хамт олондоо болон судалгаанд оролцохыг зөвшөөрч, бидний ажлыг дэмжиж ажилсан нийт оролцогчдоо талархал илэрхийлье.

Ном зүй:

1. Цөсний хүүдийн цочмог үрэвслийн оношлогоо, эмчилгээний эмнэлзүйн заавар 2021 он А\695 тоот тушаал
2. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд. 2022 он.

Хуудас 126-128

3. Farah Naaz Kazi, Shaurav Ghosh, J V Pranav Sharma, Shwetha Saravanan, Sanjana Patil "TRENDS IN GALLBLADDER DISEASE IN YOUNG ADULTS: A GROWING CONCERN" 2022 Aug 29
4. “Дотрын өвчин судлал” Б.Гомбосүрэн, УБ хот. 2013 он.
5. “Дотрын эмчийн гарын авлага” УБ хот. 2016 он.
6. Нойр булчирхайн цочмог үрэвслийн оношлогоо, эмчилгээний эмнэлзүйн заавар 2021 он А\696 тоот тушаал
7. Тархвар судлалын судалгааны аргууд Ц.Сэлэнгэ .УБ хот . 2020 он.
8. Хоол боловсруулах эрхтний эмгэг. 2009 он. Хуудас 329-416
9. Хоол боловсруулах эрхтний эмгэг. 2014 он. Хуудас 332-419
10. Хүний физиологи. УБ хот, 2023 он. Хуудас 324-347
11. Хүний эмгэг үйл судлал. УБ хот, 2010 он, Хуудас 296-297
12. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн хураангуй. УБ хот. 2012 он. Хуудас 168-172
13. Kim HS, Cho SK, Kim CS. Park JS: Big data and analysis of risk factors for gallbladder disease in the young generation of Korea. PLoS One. 2019, 14:e0211480. 10.371/journal.pone.0211480
14. Fosburg RG: Gallstones in young adults: an analysis of 178 patients under thirty years of age . Am J Surg. 1963, 106:82-8. 10.1016/0002-9610(63)90194-6

ABSTRACT

SOME DIGESTIVE SYSTEM DISORDERS
AFFECTING FACTORS

G.Chantsaldulam¹, Yu.Baasandorj¹, N.Baasanjargal¹, Kh.Zandarmaa¹, D.Oyuntsetseg²
Gobi-Altai Medical School of MNUMS,
Department of Pharmacology and Biomedicine
Email: Chantsaldulam.g@mnums.edu.mn
Tel: 86200095

Introduction: According to epidemiological studies conducted in Mongolia over the past decade, diseases of the digestive system have consistently ranked second in terms of morbidity and fourth in mortality. With the rapid advancement of technology, sedentary lifestyles and unhealthy living habits have become more prevalent among the population, leading to a trend of digestive disorders affecting younger age groups. Therefore, investigating the prevalence, pathological changes, and risk factors associated with gallbladder and pancreatic diseases among university students has become the rationale for this study.

Objective: To study the prevalence of gallbladder and pancreatic disorders and determine some of the associated risk factors.

Methodology. 200 students from the first to sixth year were selected through random sampling based on the WHO age classification. Data collection included a structured questionnaire and ultrasound examination using the SUN-800D device. Diagnostic criteria followed the national clinical guidelines for acute cholecystitis.

Results: Out of 200 participants, 120 (60%) were female and 80 (40%) were male. Among them, 128 students (64%) reported skipping breakfast regularly, and 147 (73.5%) did

not consume an adequate amount of fluids daily. Ultrasound examinations revealed that 104 students (52%) had some form of gallbladder or pancreatic abnormality. Additionally, gallstones were detected in 1 student (0.5%), and gallbladder polyps were found in 5 students (2.5%). **Conclusion:** Gallbladder and pancreatic abnormalities were observed in 52% of the participants. Among the associated risk factors, 64% of students reported skipping breakfast, and 73.5% had inadequate daily fluid intake. The ultrasound findings showed that 47% had biliary sludge, 32% had gallbladder kinking, and 48.5% had increased pancreatic echogenicity. **Keywords:** gallbladder, pancreas, pathological changes, ultrasound examination